| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)** | **212,614,600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **212,614,600.00** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **200,614,600.00** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **4,522,399.20** |
| 210102 | Нэмэгдэл | 4,522,399.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **577,000.80** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 392,819.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 46,214.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 30,702.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,834.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 92,430.30 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,411,100.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,141,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 270,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **23,720,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.00 |
| 210602 | Тавилга | 7,920,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **167,384,100.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 167,384,100.00 |

| | | |
|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,000,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **12,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)** | **212,614,600.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **212,614,600.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **212,614,600.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 80,430,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 72,376,900.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 59,807,700.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Биеийн тамир, спортын тухай хуулийн 16-20 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант онд Архангай аймгийн Биеийн тамир, спортын газар нь 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улс тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд баг, тамирчдаа амжилттай оролцуулах, өмнөх оноос медалийн тоон үзүүлэлтийг өсгөх, материаллаг баазыг бэхжүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоог өмнөх оноос нэмэгдүүлэх, нийтийн биеийн тамирын арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж хамрагдагчдын тоог нэмэгдүүлэх зорилттой. Мөн спортын салбарын албан хаагчдын нийгмийг баталгааг хангах, боловсон хүчнээ чадавхжуулах, мэргэжлийн багш дасгалжуулагчийн дор бэлтгэл сургуулилтыг хангах.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Архангай аймгийн Биеийн тамир,спортын газар нь улсын төсвийн байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2024.06.05-нд нэмэлт өөрчлөлт орсон
- “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоол
- “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам” Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоол
- “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” Засгийн Газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Биеийн тамир,спортын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Биеийн тамир,спортын улсын хорооны даргын А/01 дугаар тушаалаар баталсан дотоод хэрэгцээнд зориулан гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн ажиллаж байна. Энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Архангай аймгийн Биеийн тамир,спортын газар нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 456,378.5 мянган төгрөгөөр буюу 23.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /Мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 | 4 |
| Бараа материал | 176,204,250.0 | 194,806,500.0 | 18,602,250.0 | 10.6 |
| Үндсэн хөрөнгө | 1,730,032,621.0 | 2,167,808,956.3 | 437,776,335.3 | 25.3 |
| **Нийт хөрөнгө** | **1,906,236,871.0** | **2,362,615,456.3** | **456,378,585.3** | 23.9 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,906,236,871.0 | 2,362,615,456.3 | **456,378,585.3** | 23.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,906,236,871.0 | 2,362,615,456.3 | **456,378,585.3** | 23.9 |

Хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 10.6 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 176,204.2 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 221,743.3 мянган төгрөг, шилжүүлэн авсан 4,087.0 бусад байдлаар 9,466.5 мянган төгрөг нийт 235,296.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 216,694.6 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 194,806.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос өссөн шалтгаан нь шинэ спорт хороонд орохтой холбогдуулан Биеийн тамир спортын улсын хорооноос 13,553.5 мянган төгрөгийн аж ахуйн материал, тусгай зориулалтын материал тэмцээн уралдаантай холбоотойгоор бусад хангамжийн материалын зардал 89,300.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 25.3 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,730,032.6 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба биеийн тамир спортын улсын хорооноос шилжүүлэн авсан 501,185.5 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 13,130.0 мянган төгрөг, нийт 514,315.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 723 тоот албан бичгээр 9,558.6 мянга төгрөгийн хөрөнгийг акталсан элэгдлийн зардал 76,154.1 мянган төгрөгөөр буурч 2,167,808.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос өссөн шалтгаан нь шинэ спорт хороонд орохтой холбогдуулан Биеийн тамир спортын улсын хорооноос сорилын техник тоног төхөөрөмж 428,805.5 мянган төгрөг, сорилын программ хангамж 72,380.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан бол төсвийн хөрөнгөөр 13,130.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрмөж, тавилга эд хогшлийг Аймгийн орон нутгийн өмчийн газрын 2024 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 255 тоот албан бичгийн дагуу худалдан авалтыг хийсэн байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 456,378.5 мянган төгрөгөөр нэмэгдэж бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 693,598.6 мянган төгрөг, улсын төсвөөс санхүүжихийг 2,897,767.0 мянган төгрөг, нийт 3,591,356.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг орон нутгийн төсвөөс 693,598.6 мянган төгрөг, улсын төсвөөс 1,230,041.4 мянган төгрөг, нийт 1,923,640.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр хянаж баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд анх батлагдсан төсвийг БТСУХ-оос цалин нэмэгдсэнтэй холбогдуулан 39,961.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн улсын төсвөөс санхүүжих дүнг 1,270,003.5

мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжих дүн 693,598.6 мянган төгрөг нийт 1,963,602.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 1,270,003.5 мянган төгрөгийг улсын төсвөөс зарцуулахаар төлөвлөж төсвийн зардлын нийт гүйцэтгэлээр 1,269,653.8 мянган төгрөг зарцуулсан байна. Гүйцэтгэл 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин, шимтгэлийн зардлаас 349.6 мянган төгрөгийг хэмнэж улсын төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| 70101- Засгийн газар тохируулагч агентлаг Биеийн тамир,спортын улсын хороо | 1,270,003.5 | 1,269,653.8 | 349.7 | 99.9 |
| 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,143,417.6 | 1,143,067.9 | 349.7 | 99.9 |
| 80305-Биеийн тамирын уралдаан,тэмцээн | 69,540.0 | 69,540.0 | - | 100 |
| 82106-Нийтийн биеийн тамир | 44,337.4 | 44,337.4 | - | 100 |
| 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж | 12,708.5 | 12,705.8 | - | 100 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус байгууллагын төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлд шинжилгээ хийж үзэхэд батлагдсан төсвийн 0.02 хувь, тайлангийн эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн үлдэгдлийн 0.3 хувь нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалтай холбоотой байна. Энэ нь төрийн албан хаагчийн үндсэн цалинг өндрөөр тооцоолж төлөвлөснөөс шалтгаалжээ.

Төсвийн төлөвлөлтөөс харахад цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг зөвхөн үндсэн цалин /210101 / дээр төлөвлөсөн нь бодит гүйцэтгэлтэй уялдахгүй байна.

Иймд цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг төлөвлөхдөө үндсэн цалин /210101/, нэмэгдэл /210102 /, унаа хоолны хөнгөлөлт /210103/, урамшуулал /210104/ гэсэн эдийн засгийн ангиллаар төлөвлөж ажиллах нь зүйтэй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтээр Биеийн тамир спортын газар нь биеийн тамирын уралдаан,тэмцээнд 72,376.9 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц сангаас тэмцээн уралдаанд 80,430.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 59,807.7 нийт 212,614.6 мянган төгрөгийг хүлээн авч, гүйцэтгэлээр хангамж, бараа материалын зардалд 4,411.1 мянган төгрөг, цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 5,099.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 23,720.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж,шагнал урамшуулал 12,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 167,384.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Архангай аймгийн Биеийн тамир спортын газар нь 2024 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

- Архангай аймгийн Биеийн тамир спортын газар нь 2024 оны Засгийн газрын 02 дугаар тогтоолын дагуу "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-аас давсан тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 2,432.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас тэмцээн уралдаанд 283,959.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### 3.5.6 Тайлант хугацааны ерөнхий чиглэлийн талаар

- Тус байгууллага нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын сангүй ба үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас ахмадын сантай холбоотой зарлага гаргаагүй байна.
- Тус байгууллага нь тайлант онд төрийн захиргааны 4 албан хаагч, ТҮСБ-13 албан хаагч төрийн үйлчилгээний -26 албан хаагч нийт батлагдсан 43 орон тоотой ажиллаж байна.
- Тайлант онд нээлттэй тендер сонгон шалгаруулах арга, худалдан авах ажиллагааг шууд худалдан авалтын аргаар зохион байгуулсан байна.
- Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 2,432.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал 283,959.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна
- Тайлант онд нэмэлт санхүүжилтын дансаар хангамж,бараа материалын зардалд 4,411.1 мянган төгрөг, цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 5,099.3 мянган төгрөг, эд хогшил,урсгал засварын зардал 23,720.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж,шагнал урамшуулал 12,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 167,384.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Ерөнхий чиглэлийн судалгааг ажлын баримтад хавсаргав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Архангай аймгийн Биеийн тамир спортын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Дашмягмар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Биеийн тамир спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг их гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны тодотгон батлагдсан төсөв **1,923,640.4** мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу **28,854.6** мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу **21,640.9** мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

Тус байгууллага нь цалин, шимтгэлийн зардал болон бусад зардлын үлдэгдэл нийт 349.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Архангай аймгийн Биеийн тамир спортын газар нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Хугацаа хоцроосон мэдээлэл нь шилэн дансны системийн шинэчлэлтэй холбоотой байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан шатны ажлыг fas.audit.mn системд 2024.10-06-2024.10.08, төлөвлөх шатны ажлыг 2025.01.06-2025.01.09-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар залруулагдаагүй нийт 16,500.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд 2 зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулан fas системээр үнэлсэн байна. Үүнд:

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 2 | 16,500.0 | 2 | 16,500.0 | 100 |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **2** | **16,500.0** | **2** | **16,500.0** | **100** |

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2023 оны 12 сарын 11-ны өдрийн Б/80 дугаар тушаалаар Биеийн тамир спортын газар нь цалингийн сангаас албан хаагчдад 16,650.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт олгож төсвийг зориулалт бус зарцуулсан. 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналт хэрэгжүүлээгүй албан шаардлагуудыг хүргүүлэн биелэлтийг Биеийн тамир спортын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 61 тоот албан бичгээр нотлохбаримтын хамт ирүүлж, fas.audit.mn системд хэрэгжилтийг 100 хувьтай үнэлүүлжээ.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цалин урамшуулал, бусад нэмэгдлийн төлөвлөлт, зарцуулалт
2. Өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт
3. Төсвийг тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй

Залруулаагүй нийт 12,631.5 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч 996.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 11,635.4 мянган төгрөгий зөрчилд 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа нь 12,631.5 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 21,640.9 мянган төгрөгөөс бага, шинж чанарын хувьд материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Биеийн тамир спортын улсын хорооны даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/309 дүгээр тушаалын дагуу газрын дарга Р.Батболдод олгосон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны олгосон тэтгэмжээс 9,961.7 мянган төгрөгийг хувь хүний орлогын албан татварыг суутгаж төсөвт шилжүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" , 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар ... албан татвар ногдуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох .

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант онд Биеийн тамир спортын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Б/74 дүгээр тушаалаар албан хаагчдад үндэслэх нотлох баримтгүйгээр 10,164.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгож төсвийг хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 382 дугаар тогтоолоор баталсан "ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИД НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ"-ын 3.1 Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгаж, албан хаагчдад олгох илүү цагийн нэмэгдлийг засгийн газрын 382 дугаар тогтоолын дагуу олгож хэвших

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өөрийн орлогын төвлөрүүлэлтэд тавих дотоод хяналттай холбоотой.

Аймгийн биеийн тамир спортын газрын харьяа Усан спорт сургалтын төвийн өөрийн орлогын төвлөрүүлэлтийн байдалд дотоод хяналт шалгалт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 41.2.1 "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж*: Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагаас олох орлогын тооцооллыг хийж урьдчилан төлөвлөж, биелэлтийг хангуулах, орлого төвлөрүүлэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээг авч ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 03 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан нэмэгдлээс ХХОАТ-ыг суутгаагүй | 1 | 996.1 | 1 | 996.1 | | | | | | | | |
| Албан хаагчдад илүү цагийг хавтгайруулан олгон | 1 | 10,164.4 | | | 1 | 10,164.4 | | | | | | |
| Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, дотоод хяналтыг сайжруулах | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | **3** | **996.1** | **1** | **996.1** | **1** | **10,164.4** | 1 | | | | | |